

Улаанбаатар хотын төвийн дүүргүүдийн хүн амын хэтийн тооцоо, 2005-2020

А.Солонго

МУИС-ийн ЭЗС-ийн ХАССТ-ийн захирал,
ахлах багши, докторант

Хотын төвийн дүүргүүдийн хувьд хүн амын ердийн осолт 1992-2005 оны хооронд харьцаанд тогтвортой байжээ. Харин Улаанбаатарыг, тэр дундша төвийн дүүргүүдийг чиглэсэн шилжих хөдөлгөөн нь улс орны хөгжлийн түрүү, нийгэм, эдийн засгийн хөгжлийн үеүндээс нягт холбоотой байсаар ирсэн бөгөөд улмаар хотын хүн амын осолтод механик осолтийн нөлөө 38с нэмэгдээв. Тухайлбал, 1992-1998 оны хооронд хотын хүн амын тоо 77.2 мянгаар нэмэгдсэн бөгөөд энэхүү өөрчлөлтийн 56.8 хувийг механик осолт бүрдүүлж байсан бол 2000-2005 оны хооронд хүн ам 178.8 мянгаар нэмэгдсэн 75.9 хувийг механик осолт эзлж байна.

Хүн амын осолтийн динамик чиг хандлага, дүүрэг тус бүрийн хүн амын жилийн дундаж осолтийн хурд, хүн амын тооны өөрчлөлтийн ердийн болон механик осолтийн эзлэх хувьд жин зэргийг харгалзан узэж, хүн амын хэтийн тооцоог 2010, 2015, 2020 онуудад доод, дунд, дээд гэсэн хувилбараар гаргахад нийслэлийн хүн амын механик осолт буюу цэвэр шилжих хөдөлгөөний ирээдүйн хандлага цашид өрөнхийдөө осохор байна. Хэтийн тооцоогоор хамгийн олон хүн амттай байх дүүрэг нь доод болон дунд хувилбараар Баянзүрх, дээд хувилбараар Сонгинохайрхан дүүрэг байх төлөвлөтэй байна. Харин хамгийн цөөн хүн амттай байх дүүрэг нь алч хувилбараар Хан-Уул дүүрэг орж байна. Хот төвлөлтийн стратеги, засаг захиргааны нэгжийн хүрээний тээвэр, дэд бүтцийн хөгжлийн стратегийн зорилтот дүүргүүд нь Баянзүрх, Сонгинохайрхан, Хан-Уул дүүргүүд болох нь харгадж байна. Хөгжлийн зүй тогтолцын хувьд: Монгол улсын хүн амын наслын бүтэц, түүний ирээдүйн хандлагыг авч узхээд залуучуудын буюу 15-34 наслыгын эзлэх хувьд жин хамгийн ондор байна. Ирээдүйн хүн амын эзхүү наслын бутцайг шилжин ирэгчдийн хүн ам зүйн шинж байдалтай холбон авч узва Улаанбаатар уруу чиглэсэн шилжих хөдөлгөөн буурахгүй байх нэг нөхцөл болж байна. Ногоотэйгүүр, шилжин ирэгчдийн хөтөд дасан зохицож, амьдрал ахуй нь тогтвортажийн хирээр хамаатан, садан танигуудын сүжээ улам бэхжин тэлж, хөдөө орон нутгаас энэхүү сүлжээгээр дамжин шилжин ирэсэд цашид нэмэгдсээр байх нөхцлийг бүрдүүлж байна. Хүмүүсийн сонголт хийх боломж нэмэгдсэйн хэрээр амьдрах нөхцөл илүү сайн байгаа, хөгжил ондор байгаа тэр л газар нутаг уруу тэмүүлэх хүснэгтэй ондор байгаа нь шилжих хөдөлгөөний ирээдүйн хандлагыг тодорхойлох бас нэг нөхцөл болж байна.

Хүн амын осолт, шилжих хөдөлгөөний нөлөө хамгийн ондор байгаа Баянзүрх, Сонгинохайрхан дүүргүүн хүн ам, ядуурал, нийгэм, эдийн засаг, дэд бүтцийн түүгээдсан асуудал дараагийн 15 жилд үргэлжлэх төлөвлөгөөний байна. Иймд Мянганы хөгжлийн зорилт болон Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хотолборт ирээдийн орон сууцны асуудлыг шийдвэрлэх талаар авсан томдохон амгалтуудыг шийдвэрлэхэд ний тэрэгүүнд эдгэр дүүргүүдээс эхлэх шаардлагат зүй ёсоор тавигдаж байна.

1. Төвлөрсон толовлогеөт эдийн засгийн үеийн Улаанбаатар хотын хүн амын осолт: 1950-1990

Монгол улсын хүн ам зүйн үйл явцыг авч үзэхэд хот уруу чиглэсэн шилжих хөдөлгөөн нь цоо шинэ асуудал биш бөгөөд 1940-өөд оноос нийслэл болон төв суурин газруудад засаг захиргааны нэгжүүд төвлөрч, үйлдвэр, аж ахуйн нэгжүүд олноор байгуулагдан, тэдгээрт ажиллах хүч шаардагдаж эхэлснээр хөдөөнөөс хотод шилжин суурьших явдлыг дэмжиж, улмаар хүн ам хотод суурьших нөхцлийг бүрдүүлсэн юм. Тухайлбал, 1946-1950 оны хооронд хотын хүн ам жилд дунджаар 14.4

хувиар өсч байжээ. 1956 оны хүн амын тооллогоор нийслэлд 118.4 мянган хүн ам амьдарч байсан бол 1965 онд 236.7 мянга болж 9 жилийн хугацаанд даруй 50 орчим хувиар өссөн байна. 1960-аад оны дунд үеэс Дархан хот, 1970 оны дунд үеэс Эрдэнэт хот байгуулагдсан нь нийслэлийг чиглэсэн шилжих хөдөлгөөнийг сааруулж, шинээр байгуулагдаж буй хотуудуруу ажиллагсадыг татах эхэлсэн юм. Тухайн үед шилжих хөдөлгөөнийг хянан, ажлын байрны эрэлт, хэрэгцээтэй уялдуулж байснаар ажиллах хүчиний тархалт, байршилтын асуудал шийдвэрлэгдэж байжээ¹. Зураг 1-д 1950-1990 оны нийслэлийн хүн амын осолтийг харууллаа.

¹ НХХЯ, НҮБ-ын ХАС, 2001. «Хүн ам ба Хөгжлийн үзүүлэлт: илтгэлийн хураангуй

Зураг 1. Хүн амын тоо ба жилийн дундаж осолтний хурд, Улаанбаатар, 1950-1990



2. Зах зээлийн шилжилтийн үеийн Улаанбаатар төвийн дүүргүүдийн хувь амын эсolt: 1992-2005

1990-ээд оноос хойш гарсан нийслэлийн хүн ам зүйн өөрчлөлтүүд өвөрмөц онцлогтой байв. Төрөлтийн түвшний огцом бууралт нь үндэсний хүн амын цэвэр өсөлтөд голлох нөлөө узуулж байгаа хэдий ч дотоод шилжих хөдөлгөөн нэмэгдэж байгаа нь нийслэл болон аймгуудын хүн амын өсөлтөд срдийн өсөлтөөс илүү механик өсөлтийн нөлөөг эрс нэмэгдүүлсээр байна.

Зураг 2-т нийслэлийн төвийн зургаан дүүргийн хүн амын өсөлтийг харуулав.

Албан ёсны статистик мэдээгээр 1992 онд Улаанбаатар хотын Баянгол, Баянзүрх, Сүхбаатар, Сонгинохайрхан, Чингэлтэй, Хан-Уул зэрэг төвийн 6 дүүрэгт нийтдээ 575,0 мянган хүн ам амьдарч байсан бол 2005 онд 896,8 мянганд хүрч өнгөрсөн 13 жилийн хугацаанд хүн амын тоо хэмжээ 58.8 хувиар нэмэгджээ. Хүн амын жилийн дундаж өсөлт 1999 онд 15.57 болсон нь хамгийн оргил үе байв.

Зураг 2. Хүн амын тоо ба жилийн дундаж өсөлтийн хурд,
Улаанбаатар, төвийн дүүргүүд, 1992-2005



Мэдээллийн эх үүсвэр: Улаанбаатар хотын ЗДТГ, 2006. Улаанбаатар хотын хүн амын статистик, албан хэргүүцэнд

Өмнө дурьдаж байсанчлан 1990 оноос өмнө буюу социализмын жилүүдэд Монголд дотоод шилжих хөдөлгөөнийг хатуу хянаж байсан бөгөөд 1992 оны шинэ Үндсэн хуулиар иргэдийн шилжих хөдөлгөөнийг чөлөөтэй болгосноор нийгэм, эдийн засгийн тогтолцооны өөрчлөлт, бус нутгийн хөгжлийн ялгавартай байдлаас хамааран төвийн бүсийн аймаг, хотууд ялангуяа, Улаанбаатар хот уруу чиглэсэн шилжих хөдөлгөөний урсгал эрчимжив. Энэ үеийн нийслэлийн төвийн дүүргүүдийн хүн амын өсөлтийг нийгэм, эдийн засгийн хөгжил, хууль тогтоомжийн өөрчлөлттэй холбон дараах байдлаар бүлэглэн авч үзэж болохоор байна. Үүнд:

1992-1998 оны хоорондох хүн амын жилийн дундаж өсөлт харьцангуй тогтвортой байв. Энэ үе нь зах зээлийн шилжилтийн эхлэл үе байнсны зэрэгцээ, 1992 онд Монгол улсын анхны Үндсэн хууль батлагдсанаар иргэд оршин суух газраа чөлөөтэй сонгох эрхээ хуулиар баталгаажуулсан билээ. Улмаар хөдөөнөөс хот, төвийн бус рүү чиглэсэн шилжих хөдөлгөөн нэмэгдсэнэй зэрэгцээ мал хувьчилж эхэлснээр хотоос хөдөө рүү чиглэсэн шилжих хөдөлгөөн ч мэдэгдэхүйц нэмэгдсэн байна. Түүнчлэн шилжилтийн эхний жилүүдийн нийгэм, эдийн засгийн хямралаас үүдэн төрөлтийн түвшин огцом буурч, хүн амын өсөлтийн бууралтын үндсэн шалтгаан болох болов. Нийслэлд шилжин ирэгчдийн нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд шаардлагатай хөрөнгийг хуримтлуулах, шилжих хөдөлгөөний урсгалыг сааруулах зорилгоор 1995 оны Нийслэлийн ИТХ-ын 69-р тогтоол гарч, шилжин ирэгчдээс бүртгэлийн татвар хураамж авч эхэлсэн байна.

1999-2001 оны хоорондох хүн амын өсөлт ялангуяа, хотын хүн амын өсөлтөнд механик өсөлтийн нөлөө эрс нэмэгдэв. Ядуурал, ажлын байрны хомдол, жил дараалсан зуд, ган гачгаас үүдэн хөдөөгийн эдийн засаг бараг сонголтгүй болж орон нутгаас нийслэлийг чиглэсэн шилжих хөдөлгөөний урсгал эрс өссөн байна.

Тухайлбал, 2000 оны хүн ам орон суудны тооллогоор Улаанбаатар хотын хүн амын гуравны нэгийг орон нутгаас шилжин ирэгсэд эзэлж байжээ. Түүнчлэн төрснөөс хойшхи шилжих хөдөлгөөнд Улаанбаатар уруу чиглэсэн хамгийн том урсгал Баруун бус нутгаас (88.6 мянган хүн), хамгийн бага нь Зүүн бус нутгаас (29.9 мянган хүн) байв². Үүнтэй уялдан 2000 онд Нийслэлийн ИТХ-ын 47-р тогтоол гарч шилжин ирэгчдээс авч буй бүртгэлийн хураамжийг бараг хоёр дахин нэмж 50000 төгрөг болгов. Өсөн нэмэгдэж буй механик өсөлтийн нөлөө хотын хүн ам тэр дундаа гэр хороололд илүү тод илэрч эхэлсэн төдийгүй ядуурлын түвшин орон нутагт биш хотод өндөр болов.

2002-2005 оны үеэс Монголын эдийн засагт зарим нэг нааштай өөрчлөлтүүд гарч эхлэв. Шилжилтийн жилүүдийн өнгөрсөн үетэй харьцуулахад эдийн засагт өсөлт бий болж эхлэв. Гэсэн хэдий ч хот, хөдөөгийн хөгжлийн тэгш бус байдал нэмэгдсээр, орлогын ядуурал хөдөөд тэр дундаа сумын төвд хамгийн өндөр³ болж, ажлын байр хайх, зах зээлд ойртох зорилгоор мөн л нийслэл болон төвийн бусийг чиглэсэн шилжих-хөдөлгөөний урсгал үргэлжилсээр байна. 2003 онд Хүний эрхийн үндэсний комисс Монгол улсын шүүхэд хандснаар шилжин ирэгчдээс авч байсан бүртгэлийн хураамжийг 2004 оноос хүчингүй болгов. Бүртгэлийн хураамжийг чөлөөлснөөс үүдэн 2004-2005 онд л гэхэд нийслэлийн зарим дүүрэгт хүн амын жилийн дундаж өсөлт б хувиас ч хол давжээ.

Шилжин ирэгсэд голдуу нийслэлийн гэр хороололд амьдарч байгаа бөгөөд Сонгинохайрхан, Баянзүрх дүүргийн хүрээг улам бүр тэлсээр байна. Хотын түүхэн уламжлал, хот төлөвлөлт, байгалийн нөхцөл, дүүргүүдийн эдийн засгийн үргийн харилцан адилгүй байдал зэргээс шалтгаалан хүн амын тархалт дүүргүүдээр харилцан адилгүй байна. Тухайлбал, төвийн дүүргүүдийн нийт хүн амын 22.8 хувь нь Сонгинохайрхан, 21.9 хувь нь Баянзүрх, 17.9

² УСГ, 2002. Монгол улсын дотоод шилжих хөдөлгөөн, хотжилт: 2000 оны хүн ам, орон суудны тооллого, Улаанбаатар

³ АХБ, НУБХХ, УСГ, 2004. Өрхийн амьжиргээн түвшний судалгаа, 2003, Улаанбаатар

хувь нь Баянгол, 14.6 хувь нь Чингэлтэй, 13.1 хувь нь Сүхбаатар үлдсэн 9.8 хувь нь Хан-Уул дүүрэгт тус тусаж төрж байна⁴. Нэг хороонд оршин сууж буй хүн амын тоогоор Сонгинохайрхан, Баянгол, Баянзүрх дүүрэг бусад дүүргээс дээгүүрт орж байгаа бөгөөд Баянгол, Чингэлтэй, Сүхбаатар дүүрэгт хүн амын нягтрал хамгийн их буюу нийслэлийн дунджаас дээгүүр байна.


3. Улаанбаатарын төвийн дүүргүүдийн хүн амын өсөлт ба хэтийн төлов

3.1 Хүн амын өсөлтийн өвөөгийн байдал

Улаанбаатар хотын төвийн дүүргүүдийн хүн амын өсөлтийн түвшинг Зураг 3-д ердийн болон механик өсөлтөөр дэлгэрэнгүй

бол 2000-2005 оны хооронд хүн ам 1 мянгаар иэмэгдсний 75.9 хувийг механик өсөлтэй эзэлж байна.

Дээр өгүүлж байсанчлан, хот хөдөөг хөгжлийн ялгаа, жил дараалсан зуд, ядуу ажлын байрны хомсдол зэрэг түлхэх хүзүүлсийн нөлөөгөөр нийслэлийг бараадаа их нүүдэл нэмэгдснийг цаг хугацааны динамик үр дүн гэрчилж байна. 2000 онд механик өсөлтийн оргил үе байсан бөгөөд бүртгэлийн хураамжийг мөн онд хүчинь болгомогц өмнөх жилүүдэд шилжин ирж бүртгэлгүй байсан иргэд бүртгэлд түүхийн хамрагдсан явдал үүнд нөлөөлсөн бөгөөд болох юм. Учир нь 2005 онд энэхүү өвөөгийн эргээд буурчээ.



харууллаа. Хотын төвийн дүүргүүдийн хувьд хүн амын ердийн өсөлт 1992-2005 оны хооронд харьцангуй тогтвортой байжээ. Харин Улаанбаатарыг, тэр дундаа төвийн дүүргүүдийг чиглэсэн шилжих хөдөлгөөн нь улс орны хөгжлийн түүх, нийгэм, эдийн засгийн хөгжлийн үеүйтэй нягт холбоотой байсаар ирсэн бөгөөд улмаар хотын хүн амын өсөлтөд механик өсөлтийн нөлөө эрс иэмэгдэв. Тухайлбал, 1992-1998 оны хооронд хотын хүн амын тоо 77.2 мянгаар иэмэгдсэн бөгөөд энэхүү өөрчлөлтийн 56.8 хувийг механик өсөлт бүрдүүлж байсан

3.2 Хүн амын өсөлтийн хэтийн төлов

Хүн амын өсөлтийн динамик чиг хандын дүүрэг тус бүрийн хүн амын жилд дундаж өсөлтийн хурд, хүн амын төхөөрөлтөнд ердийн болон механик өсөлтийн эзлэх хувийн жин зэрэг харгалзан үзэж, хүн амын хэтийн тоо 2010, 2015, 2020 онуудаар доод, дунд, гэсэн хувилбараар гаргалаа.

Доод хувилбар: Төвийн дүүргүүдийн хүн амын өсөлт 1992-1998 оны чиг хандын дүүрэлжлэх бөгөөд өсөлт харьцаа

⁴ Улаанбаатар хотын ЗДТГ, 2006. Улаанбаатар хотын хүн амын статистик, албан хөргүүцөнд

тогтвортой байна. Нийт өсөлтөнд механик өсөлтийн нөлөө илүү байх боловч ердийн болон механик өсөлтийн зөрүү харьцангуй бага байна. Хөдөөд чиглэсэн хөрөнгө оруулалт, бүсчилсэн хөгжлийн үр нөлөөгөөр хот уруу чиглэсэн шилжих хөдөлгөөн эрс саарна гэсэн таамаглалыг дэвшүүллээ. Нөгөө талаас, засгийн газраас авч хэрэгжүүлж буй хalamжийн сангийн тодруулбал, шинээр төрсон хүүхэд, насанд хүрээгүй хүүхдүүд болон залуу хосуудад зориулсан нийгмийн хalamжийн сангийн зардал цаашид үргэлжлэх бөгөөд нийгмийн энэхүү урамшуулал, дэмжлэг нь хотын хүн амын гэрлэлт болон төрөлтийн түвшинг мэдэгдэхүйц нэмэгдүүлэх болно.


Дунд хувилбар: Төвийн дүүргүүдийн хүн амын өсөлт 2000-2005 оны чиг хандлагаар үргэлжлэх болно. Өөрөөр хэлбэл, хэтийн тооцооны суурь он буюу 2005 оноос өмнөх 5 жилийн өсөлтийн хандлага цаашид үргэлжилнэ гэж таамагласан. Хотын хүн амын төрөлтийн түвшин хэвээр хадгалагдах бөгөөд ердийн өсөлт харьцангуй тогтвортой байна. Эмэгтэйчүүдийн боловсрол, ажил эрхлэлтийн түвшингийн дээшлэлт, нөхөн үржихүйн эрүүл мэндийн хөтөлбөрүүд амжилттай хэрэгжин, гэр бүл төлөвлөлтийн арга хэрэгслийн хэрэглээ, хүртээмж улам бүр нэмэгдэхийн хэрээр төрөлтийн түвшин өсөхгүй. Нөгөөтэйгүүр эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж сайжирснаар нас

баралтын түвшин ч аажмаар буурах болно. Хүн амын насын залуу бүтэц, хүмүүст олгогдож буй шинэ шинэ боломжууд нээгдэхийн хэрээр хөгжил өндөр хэсэг буюу хоттэрдундаанийслэлийг чиглэсэн шилжих хөдөлгөөний ургал үргэлжлэх болно. Ийнхүү нийслэлийн хүн амын өсөлтөнд ердийн өсөлтийн нөлөө мэдэгдэхүйц багасч, харин механик өсөлтийн нөлөө өндөр байх болно.

Дээд хувилбар: Хүн амын жилийн дундаж өсөлтийн хурд 2002-2005 оны түвшинтэй ижил байх бөгөөд төвийн дүүргүүдийн хүн амын өсөлтийн дийлэнхийг механик өсөлт бий болгох болно. Хүн амын амьжиргааны түвшин дээшилсэн ч хүүхдийн одоогийн өртөг нэмэгдэхийн хэрээр хотын гэр бүл, эмэгтэйчүүдтөрөлтөдөөилүүхязгаарлалт хийх болно. Хүн амын нас барагт буурах боловч ердийн өсөлтөнд төрөлтийн нөлөө өндөр хэвээр байна. Хот, хөдөөгийн хөгжлийн ялгааг багасгах тал дээр дорвийт ахиц гарахгүй, хөгжлийн ялгаа улам бүр нэмэгдэхийн хэрээр нийслэлийг чиглэсэн их нүүдлийн эрч саарахгүй үргэлжилсээр байх болно.

Ийнхүү дэвшүүлсэн таамаглалуудыг ашиглан тооцооллыг хийж, нэгтгэсэн үр дүнг Зураг 4-д гурван хувилбараар харуулав.

Зураг 4. Улаанбаатарын төвийн дүүргүүдийн хүн амын хэтийн тооцоо 2010, 2015, 2020



хувь нь Баянгол, 14.6 хувь нь Чингэлтэй, 13.1 хувь нь Сүхбаатар үлдсэн 9.8 хувь нь Хан-Уул дүүрэгт тус тус аж төрж байна⁴. Нэг хороонд оршин сууж буй хүн амын тоогоор Сонгинохайрхан, Баянгол, Баянзүрх дүүрэг бусад дүүргээс дээгүүрт орж байгаа бөгөөд Баянгол, Чингэлтэй, Сүхбаатар дүүрэгт хүн амын нягтрал хамгийн их буюу нийслэлийн дунджаас дээгүүр байна.

3. Улаанбаатарын төвийн дүүргүүдийн хүн амын өсөлт ба хэтийн төлов


3.1 Хүн амын өсөлтийн оногогийн байдал

Улаанбаатар хотын төвийн дүүргүүдийн хүн амын өсөлтийн түвшинг Зураг 3-д ердийн болон механик өсөлтөөр дэлгэрэнгүй

бол 2000-2005 оны хооронд хүн ам 178.8 мянгаар нэмэгдсний 75.9 хувийг механик өсөлт эзэлж байна.

Дээр өгүүлж байсанчлан, хот хөдөөгийн хөгжлийн ялгаа, жил дараалсан зуд, ядуурал, ажлын байрны хомсдол зэрэг тулхэх хүчин зүйлсийн нөлөөгөөр нийслэлийг бараадсан их нүүдэл нэмэгдснийг цаг хугацааны динамик үр дүн гэрчилж байна. 2004 он механик өсөлтийн оргил үе байсан бөгөөд бүртгэлийн хураамжийг мөн онд хүчингүй болгомогц өмнөх жилүүдэд шилжин ирээд бүртгэлгүй байсан иргэд бүртгэлд тулхүү хамрагдсан явдал үүнд нөлөөлсөн байж болох юм. Учир нь 2005 онд энэхүү өсөлт эргээд буурчээ.

Зураг 3. Хүн амын өсөлтийн коэффициент, Улаанбаатар, 1992-2005



харууллаа. Хотын төвийн дүүргүүдийн хувьд хүн амын ердийн өсөлт 1992-2005 оны хооронд харьцангуй тогтвортой байжээ. Харин Улаанбаатарыг, тэр дундаа төвийн дүүргүүдийг чиглэсэн шилжих хөдөлгөөн нь улс орны хөгжлийн түүх, нийгэм, эдийн засгийн хөгжлийн үеүйтэй нягт холбоотой байсаар ирсэн бөгөөд улмаар хотын хүн амын өсөлтөд механик өсөлтийн нөлөө эрс нэмэгдэв. Тухайлбал, 1992-1998 оны хооронд хотын хүн амын тоо 77.2 мянгаар нэмэгдсэн бөгөөд энэхүү өөрчлөлтийн 56.8 хувийг механик өсөлт бүрдүүлж байсан

3.2 Хүн амын өсөлтийн хэтийн төлөв

Хүн амын өсөлтийн динамик чиг хандлага, дүүрэг тус бүрийн хүн амын жилийн дундаж өсөлтийн хурд, хүн амын тооны өөрчлөлтөнд ердийн болон механик өсөлтийн эзлэх хувийн жин зэргийг харгалzan үзэж, хүн амын хэтийн тооцоог 2010, 2015, 2020 онуудаар доод, дунд, дээд гэсэн хувилбараар гаргалаа.

Доод хувилбар: Төвийн дүүргүүдийн хүн амын өсөлт 1992-1998 оны чиг хандлагаар үргэлжлэх бөгөөд өсөлт харьцангуй

⁴ Улаанбаатар хотын ЗДТТ, 2006. Улаанбаатар хотын хүн амын статистик, албан ѫрээгчид

тогтвортой байна. Нийт өсөлтөнд механик өсөлтийн нөлөө илүү байх боловч ердийн болон механик өсөлтийн зөрүү харьцангуй бага байна. Хөдөөд чиглэсэн хөрөнгө оруулалт, бүсчилсэн хөгжлийн үр нөлөөгөөр хот уруу чиглэсэн шилжих хөдөлгөөн эрс саарна гэсэн таамаглалыг дэвшүүллээ. Нөгөө талаас, засгийн газраас авч хэрэгжүүлж буй халамжийн сангийн тодруулбал, шинээр төрсөн хүүхэд, насанд хүрээгүй хүүхдүүд болон залуу хосуудад зориулсан нийгмийн халамжийн сангийн зардал цаашид үргэлжлэх бөгөөд нийгмийн энэхүү урамшуулал, дэмжлэг нь хотын хүн амын гэрлэлт болон төрөлтийн түвшинг мэдэгдэхүйц нэмэгдүүлэх болно.


Дунд хувилбар: Төвийн дүүргүүдийн хүн амын өсөлт 2000-2005 оны чиг хандлагаар үргэлжлэх болно. Өөрөөр хэлбэл, хэтийн тооцооны суурь он буюу 2005 оноос өмнөх 5 жилийн өсөлтийн хандлага цаашид үргэлжилнэ гэж таамагласан. Хотын хүн амын төрөлтийн түвшин хэвээр хадгалагдах бөгөөд ердийн өсөлт харьцангуй тогтвортой байна. Эмэгтэйчүүдийн боловсрол, ажил эрхлэлтийн түвшингийн дээшлэлт, нохөн үржихүйн эрүүл мэндийн хөтөлбөрүүд амжилттай хэрэгжин, гэр бүл төлөвлөлтийн арга хэрэгслийн хэрэглээ, хүртээмж улам бүр нэмэгдэхийн хэрээр төрөлтийн түвшин өсөхгүй. Нөгөөтэйгүүр эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж сайжирснаар нас

баралтын түвшин ч аажмаар буурах болно. Хүн амын насын залуу бүтэц, хүмүүст олгогдож буй шинэ шинэ боломжууд нээгдэхийн хэрээр хөгжил өндөр хэсэг буюу хоттэрдундаанийслэлийг чиглэсэн шилжих хөдөлгөөний урсгал үргэлжлэх болно. Ийнхүү нийслэлийн хүн амын өсөлтөнд ердийн өсөлтийн нөлөө мэдэгдэхүйц багасч, харин механик өсөлтийн нөлөө өндөр байх болно.

Дээд хувилбар: Хүн амын жилийн дундаж өсөлтийн хурд 2002-2005 оны түвшинтэй ижил байх бөгөөд төвийн дүүргүүдийн хүн амын өсөлтийн дийлэнхийг механик өсөлт бий болгох болно. Хүн амын амьжиргааны түвшин дээшилсэн ч хүүхдийн одоогийн өртөг нэмэгдэхийн хэрээр хотын гэр бүл, эмэгтэйчүүдтөрөлтөдөөилүүххязгаарлалт хийх болно. Хүн амын насын баралт буурах боловч ердийн өсөлтөнд төрөлтийн нөлөө өндөр хэвээр байна. Хот, хөдөөгийн хөгжлийн ялгааг багасгах тал дээр дорвигийн ахиц гараагүй, хөгжлийн ялгаа улам бүр нэмэгдэхийн хэрээр нийслэлийг чиглэсэн их нүүдлийн эрч саарахгүй үргэлжилсээр байх болно.

Ийнхүү дэвшүүлсэн таамаглалуудыг ашиглан тооцооллыг хийж, нэгтгэсэн үр дунг Зураг 4-д гурван хувилбараар харуулав.

Зураг 4. Улаанбаатарын төвийн дүүргүүдийн хүн амын хэтийн тооцоо 2010, 2015, 2020




Одоо хэтийн тооцооны онуудад ердийн болон механик өсөлт абсолют тоо хэмжээгээр ямар байхыг тодотгож үзье.

Доод хувилбар: Хэрвээ нийслэлийн хүн амын өсөлтийн хандлага 1992-1998 оны үеийнхтэй ижилхэн байвал хотын хүн амын тоо 2005-2010 оны хооронд 116255 хүнээр нэмэгдэхээс 66033 нь цэвэр шилжилтээр, 2010-2015 оны хооронд 131891 хүнээр нэмэгдэхээс 74914 нь цэвэр шилжилтээр, 2015-2020 оны 149707 хүнээр нэмэгдэхээс 85034 нь цэвэр шилжилтээр бий болох төлөвтэй байна (Зураг 5a).

Дунд хувилбар: Хэрвээ нийслэлийн хүн амын өсөлтийн хандлага 2000-2005 оны үеийнхтэй ижилхэн байвал хотын хүн амын тоо 2005-2010 оны хооронд 210198 хүнээр нэмэгдэхээс 090159540 нь цэвэр шилжилтээр, 2010-2015 оны хооронд 262877 хүнээр нэмэгдэхээс 199524 нь цэвэр шилжилтээр, 2015-2020 оны хооронд 329461 хүнээр нэмэгдэхээс 250061 нь цэвэр шилжилтээр бий болох төлөвтэй байна (Зураг 5b).

Дээд хувилбар: Хэрвээ нийслэлийн хүн амын өсөлтийн хандлага 2002-2005 оны

**Зураг 5.a. Хүн амын өөрчлөлтийн хэтийн тооцоо, бага хувилбар,
Улаанбаатарын төвийн дүүргүүд, 2005-2020**



**Зураг 5.b. Хүн амын өөрчлөлтийн хэтийн тооцоо, дунд хувилбар,
Улаанбаатарын төвийн дүүргүүд, 2005-2020**




үеийнхтэй ижилхэн байвал хотын хүн амын тоо 2005-2010 оны хооронд 259248 хүнээр нэмэгдэхээс 147258 нь цэвэр шилжилтээр, 2010-2015 оны хооронд 341936 хүнээр нэмэгдэхээс 230426 нь цэвэр шилжилтээр, 2015-2020 оны 452873 хүнээр нэмэгдэхээс 369603 нь цэвэр шилжилтээр бий болох төлөвлөхийн байна (Зураг 5c).

нь тогтвортойхийн хирээр хамаатан, садан танилуудын сүлжээуламбэхжинтэлж, хөдөө орон нутгаас энэхүү сүлжээгээр дамжин шилжин ирэгсэд цаашид нэмэгдсээр байх нөхцлийг бурдуулж байна.

3. Хүмүүсийн сонголт хийх боломж нэмэгдэхийн хэрээр амьдрах нөхцөл илүү сайн байгаа, хөгжил өндөр байгаа тэр л газар

Зураг 5.c. Хүн амын өөрчлөлтийн хэтийн тооцоо, дунд хувилбар, Улаанбаатарын төвийн дүүргүүд, 2005-2020



Хэтийн тооцооны аль ч хувилбарын үр дүнгээс харахад нийслэлийн хүн амын механик өсөлт буюу цэвэр шилжих хөдөлгөөний ирээдүйн хандлага цаашид өсөхөөр байна. Үүнийг хөгжлийн дараах зүй тогтоор тайлбарлаж болох юм. Үүнд:


1. Монгол улсын хүн амын наслын бүтэц, түүний ирээдүйн хандлагыг авч үзэхэд залуучуудын буюу 15-34 наслынхны эзлэх хувийн жинхамгийн өндөр байна. Ирээдүйн хүн амын энэхүү наслын бүтцийг шилжин ирэгчдийн хүн ам зүйн шинж байдалтай холбон авч үзвэл Улаанбаатар уруу чиглэсэн шилжих хөдөлгөөн буурахгүй байх нэг нөхцөл болж байна.

2. Хотод шилжин ирэгсдийн нийгмийн сүлжээ өөрөөр хэлбэл, нийслэлд шилжин ирэгсэд хотод дасан зохицож, амьдрал ахуй


нутаг уруу тэмүүлэх хүсэл эрмэлзэл өндөр байгаа нь шилжих хөдөлгөөний ирээдүйн хандлагыг тодорхойлох бас нэг нөхцөл болж байна. Тухайлбал, Дотоод шилжих хөдөлгөөний микро түвшний судалгаагаар судалгаанд хамрагдсан нийт хүн амын 1/4 орчим хувь нь нийслэлд шилжих хүсэлтэй байсан бөгөөд тэдний 40 орчим хувь нь нийслэлд шилжин суурьшихаар төлөвлөж байгаагаас харахад нийслэлийг зорьсны шилжих хөдөлгөөний ургасал тасралтгүй үргэлжилсээр байх нөхцөл болж байна.

2003-2005 оны дүүргүүдийн хүн амын механик өсөлтийн хандлагыг үндэслэн цэвэр шилжих хөдөлгөөний хэтийн тооцоог хийж, өсөлтийн ерөнхий хандлагыг дүүргүүдээр Зураг 5.1-Зураг 5.6-д үзүүлэв.


Зураг 5.1 Цэвэр шилжих хөдөлгөөний коэффициент, Баянгол дүүрэг




Зураг 5.2 Цэвэр шилжих хөдөлгөөний коэффициент, Баянзүрх дүүрэг




Зураг 5.3 Цэвэр шилжих хөдөлгөөний коэффициент, Сүхбаатар дүүрэг




Зураг 5.4 Цэвэр шилжих хөдөлгөөний коэффициент, Сонгинохайрхан дүүрэг



Зураг 5.5 Цэвэр шилжих хөдөлгөөний коэффициент, Чингэлтэй дүүрэг



Зураг 5.6 Цэвэр шилжих хөдөлгөөний коэффициент, Хан-Уул дүүрэг



Дүгнэлт

Улаанбаатарын төвийн дүүргүүдийн 2010-2020 оны хүн амын хэтийн тооцоогоор хамгийн олон хүн амтай байх дүүрэг нь доод болон дунд хувилбараар Баянзүрх, дээд хувилбараар Сонгинохайрхан дүүрэг байх төлөвтэй байна. Харин хамгийн цөөн хүн амтай байх дүүрэг нь аль ч хувилбараар Хан-Уул дүүрэг байна. Хот төлөвлөлтийн стратеги, засаг захиргааны иэгжийн хүрээний тэлэлт, дэд бүтцийн хөгжлийн стратегийн зорилтот дүүргүүд нь Баянзүрх, Сонгинохайрхан, Хан-Уул дүүргүүд болох нь эндээс харагдаж байна. Хүн амын ёсөлт,

шилжих хөдөлгөөний нөлөө хамгийн өндөр байгаа Баянзүрх, Сонгинохайрхан дүүргийн хүн ам, ядуурал, нийгэм, эдийн засаг, дэд бүтцийн тулгамдсан асуудал дараагийн 15 жилд үргэлжлэх төлөвтэй байна. Иймд Мянганы хөгжлийн зорилт болон Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт иргэдийн орон сууцны асуудлыг шийдвэрлэх талаар авсан томоохон амлалтуудыг шийдвэрлэхэд нэн тэргүүнд эдгээр дүүргүүдээс эхлэх шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Ашигласан материал

1. АХБ, НҮБХХ, ҮСГ, 2004. Өрхийн амьжиргааны түвшний судалгаа, 2003, Улаанбаатар
2. НХХЯ, НҮБ-ын ХАС, 2001.» Хүн ам ба Хөгжил» дээд хэмжээний уулзалт: илтгэлийн хураангуй
3. Улаанбаатар хотын ЗДТГ, 2006. Улаанбаатар хотын хүн амын статистик, албан хэрэгцээнд
4. ҮСГ, 2002. Монгол улсын дотоод шилжих хөдөлгөөн, хотжилт: 2000 оны хүн ам, орон суудны тооллого, Улаанбаатар
5. ҮСГ, 2002. Монголын хүн амын хэтийн тооцоо, Улаанбаатар
6. ХАССТ, НХХЯ, НҮБХХ, 2004. Улаанбаатар хотын ядуурал ба шилжих хөдөлгөөн, Бүлэг 6, Улаанбаатар
7. ХАССТ, НХХЯ, НҮБХХ, 2000. Дотоод шилжих хөдөлгөөний микро түвшний судалгаа, Улаанбаатар